



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/326

Мандалговь

“Аймгийн” Шилдэг багш” нарыг шалгаруулж,  
урамшуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/326 дугаар захирамжаар батлагдсан “Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бүтээлч багш нарыг урамшуулах журам”-ын 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2017 оны аймгийн “Шилдэг багш”-аар нэр бүхий 10 багшийг журмын дагуу шалгаруулж тус бүр өргөмжлөл, 1,000,000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг багшаар шалгарсан багш нарын нэрсийг 1 дүгээр, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 10.270.000 /Арван сая хоёр зуун далан мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГазар /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О БАТ-ЭРДЭНЭ

0200922

